



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 03 өдөр

Дугаар А/88

Цагаан-Уул сум

Г Г

**Шалгарсан төслүүдийг санхүүжүүлэх  
тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хууль, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн Сайдын А/521 тоот тушаалын “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх журам”, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2024 оны 02 дугаар сарын 23-ны 12 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Хоршоо хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах комиссын шийдвэрээр шалгарсан төслийг санхүүжүүлэх, зээлийг олгох ажлыг зохион байгуулж төсөлд шаардагдах материалуудыг бүрэн болгохыг хүнс, хоршоо, жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн (М.Оюунчимэг)-т үүрэг болгосугай.

2. Цахьяа бизьяа хоршооны “Сумандаа өнгө нэмье” төсөл 20.000.000 төгрөг, Сангийн далай шарга хоршооны “Ногоон тэжээл” төсөл 25.000.000 төгрөг тус тус олгохыг зөвшөөрсүгэй.

3. Сангийн хөрөнгийг зориулалтын бус, үр ашиггүй зарцуулсан нь энэ журмын 7.1-т заасан зохистой харьцааны шалгуур хангаагүй болон эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт шалгалтаар тогтоогдсон бол Төсөв, санхүүгийн болон Жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдийн хамтарсан шийдвэрээр сангийн хөрөнгийг татан төвлөрүүлэн дахин хуваарилж ажиллахыг хоршоо хөгжүүлэх сангийн төслийн хяналтын / комисс /-д даалгасугай.

4. Хоршоо хөгжүүлэх сангаас авсан зээлээ үр дүнтэй ашиглаж, бизнесээ өргөжүүлэн тайлан мэдээг цаг тухайд нь гаргаж Хүнс, хоршоо, жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн (М.Оюунчимэг)-т хүлээлгэн өгөхийг төсөл хэрэгжүүлэгч (Сангийн далай шарга хоршооны Д.Дашзэгвэ), (Цахьяа бизьяа хоршооны О.Солонго), нарт даалгасугай.

5. Хоршоо хөгжүүлэх сангаас зээл авч төсөл хэрэгжүүлж байгаа зээлдэгчийн материалтай танилцаж зээл олгохыг Хоршоо хөгжүүлэх сангийн нягтлан (Ж.Пүрэвжав)-д зөвшөөрсүгэй.

6. Хоршоо хөгжүүлэх сангаас зээл авч төсөл хэрэгжүүлж байгаа зээлдэгчийн материалыг хянаж зээл олгохыг Санхүүгийн албаны дарга (Ш.Эрдэнэцэцэг)-д зөвшөөрсүгэй.

7. Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн хэрэгжилтэнд байнгын хяналт тавьж удирдлагаар хангаж, тайлан мэдээг цаг тухайд нь гаргахыг Хүнс, хоршоо, жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн (М.Оюунчимэг) болон (хяналтын комисс)-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



С.ГОНЧИГНЯМ